

Ноагийн үерээс хойш их цаг хугацаа өнгөрөв.

Дэлхий дээр Ноагийн үр удам олширч, хамтдаа амьдарцгааж, бүгд нэг хэлээр ярьдаг байлаа.

Тэд дорно зүг уруу нүүж, Шинар газрын нэгэн талд хамтдаа нутаглан суух болжээ.

Хүмүүс олуулаа амьдарч байсан учир тосгон ч аажмаар томорч эхэлжээ.

Хүмүүс ухаантай болох түсам Бурханыг тоохгүй амьдрах болов.

Тэд харин ч өөрсдөө Бурхан шиг болохыг бодож эхэлжээ.

Бага багаар шуналтай болж байгаа хүмүүс маш өндөр цамхаг барьж эхэлжээ.

Хүмүүс тэнгэрт тулам өндөр цамхагийг барьцгаая хэмээн барьж эхлэв.

Хүмүүс энэ цамхгийг барихаасаа өмнө Бурханаас ч асуулгүйгээр өөрсдөдөө таалагдахаар барьж эхлэв. Хүмүүс бардам болж, Бурханыг хүндэтгэх сэтгэлгүй болсон байлаа.

Бурхан хүмүүсийн барьж байгаа цамхгийг харжээ. Тэр цамхаг Бурханд таалагдсангүй.

Тиймээс Бурхан тэднийг нэг болгохгүйн тулд тэдний хэлийг өөр өөр болгон сольж хутгалдуулан орхижээ.

Би биенээ буруу ойлголцож байсан тул ихэд үймэцгээн хамтдаа амьдрах боломжгүй болжээ.

Тэнгэрт тултал барьж байсан цамхгаа орхин тус тусын замаараа явцгаажээ.

Ийм сонин гайхалтай зүйл болсонд тэд, Бурхан хүч чадалтай Нэгэн болохыг мэдэж авчээ.

Тэгээд хамтдаа барьж байсан цамхгаа “Бабел” гэж нэрлэжээ.



Бүтээлч байцгаая 1. Доорх асуултад хариулаарай.

а. Хүмүүсийн барьж эхэлсэн өндөр цамхаг ямар нэртэй байсан бэ?

б. Хүмүүс юуны төлөө өндөр цамхгийг барьж байсан бэ?

в. Бабел цамхгийг барьж байсан хүмүүсийг Бурхан ямар аргаар зогсоосон бэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Эхлэл 11:9)

ЭЗЭН бүх газар дэлхийн хэлийг хутгалдуулан самууруулсан уг газрыг Бабел гэж нэрлэв.
ЭЗЭН тэднийг тэндээс бүх дэлхий даяар тараасан билээ.



Бүтээлч байцгаая 2. Бурханы хаант улсад зориулсан бат бөх цамхаг барихын тулд та ямар тоосго ашиглах вэ? Хариултаа харуулахын тулд тоосгон дээр "Х" тэмдэг тавиарай.

Бурханы хаант улсад зориулсан бат бөх цамхаг барихын тулд та ямар тоосго ашиглах вэ? Хариултаа харуулахын тулд тоосгон дээр "Х" тэмдэг тавиарай.

талархал

үйтгэр гүниг

сэргэлэн цовоо

хулгай

дуулгавартай
байдал

худал үг

үзэн ядах

алах хөнөөх

муухай бодол

дуулгаваргүй
байдал

зөрчилдөөн

хүндлэл

ЭНЭРЭЛ

найдвар

уур хилэн

амар
тайван

дөлгөөн байдал

баяр хөөртэй

Заль МЭХ

ҮНЭНЧ

бардам байдал

ТЭВЧЭЭР

хайр

өрсөлдөөн

хуурамч шүтээн

эв найрамдал

хэрүүл

